



**ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2017 оны 09 сарын 19 өдөр

Дугаар А/537

Эрдэнэт


Дэмжлэг үзүүлэх тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5/a/, 29.2, Соёлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн ээлжит 4 дүгээр хуралдааны 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2017 оны 10 дугаар сарын 12-15-ны өдрүүдэд Дундговь аймагт зохион байгуулагдах “Олон улсын өсвөрийн циркчдийн III наадамд Орхон аймгийг төлөөлөн оролцох 4 дүгээр сургуулийн сурагчид болон Хүүхэд залуучуудын театрын цирк ангийн сурагчдын зардал 1460000 /Нэг сая дөрвөн зуун жаран мянган/ төгрөгийн дэмжлэгийг хавсралтад тусгаснаар олгосугай.


2.Шаардагдах зардал 1460000 /Нэг сая дөрвөн зуун жаран мянган/ төгрөгийг Засаг даргын нөөц сан хуваарилагдаагүй бусад зардлын жагсаалтын “Соёл ,спорт хүүхэд залуучууд, олон нийтийн арга хэмжээг жилийн туршид зохион байгуулах” арга хэмжээний зардлаас гаргахыг Санхүү, Төрийн сангийн хэлтэс /н.Бямбацэцэг/-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Д.БАТЛУТ

Аймгийн Засаг даргын 2017 оны
09 дүгээр сарын 19-ны өдрийн
537 дугаар захирамжийн хавсралт



ЗАРДЛЫН ТӨСӨВ

Д/д	Зардлын төрөл	Нэг бүрийн үнэ /төгрөг	Тоо, хэмжээ	Нийт үнэ/төгрөг/
1	Замын зардал / Эрдэнэт -УБ, УБ-Эрдэнэт ирэх, буцах/	30000	37	1110000
2	Бурхан үзүүлбэрийн тавцан	175000	2	350000
	Дүн			1460000

000